



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БАЯНХОНГОР АЙМГИЙН БААЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

АУДИТЫН КОД: БНА-2021/5/СТА/ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2021 он</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Б.Цэрэнчимэд Утас: 88117644 Цахим хаяг: tserenchimedb@audit.gov.mn</p>
---	--



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	4
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	6
2.1.Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийгдсэн нэмэлт дансны гүйцэтгэлийн тайлан.....	12
3.Аудитын тайлан	13
3.1. Ерөнхий зүйл	13
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	13
3.4. Материаллаг байдал	14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	15
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
Залруулсан алдаа	17
Аудитын зөвлөмж	17
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	17
4. Менежментийн захидал.....	17
5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	19



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

Г БААЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН Г
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Б.НАРАНБААТАР ТАНАА

2021.02.25 № 2/147

танай _____ -ны № _____ -т

Г **АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ** Г

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баацагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баацагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын удирдлага нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг сумын Засаг даргаар батлуулан биелэлтийг тооцон ажилласан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

2021 А4 ТООТ

• 005020133

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ



Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

2.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>19,281,018.00</u>	<u>27,322,743.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	19,281,018.00	27,322,743.00
354	Хангамжийн материал	18,855,218.00	27,322,743.00
35410	Бичиг хэргийн материал	5,181,055.00	5,234,485.00
35420	Аж ахуйн материал	13,674,163.00	12,592,058.00
35470	Бусад хангамжийн материал	00.00	9,496,200.00
35600	Мал амьтад	425,800.00	00.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,208,837,197.96</u>	<u>1,155,659,869.00</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,208,837,197.96	1,155,659,869.00
392	Биет хөрөнгө	1,140,221,197.96	1,087,043,869.00
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,108,630,096.67	1,133,036,550.67
39202	Хуримтлагдсан элэгдэл	-223,073,387.55	-266,751,836.91
39203	Авто-тээврийн хэрэгсэл	180,699,800.00	180,699,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-96,575,253.67	-115,732,880.18
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	230,348,849.64	241,629,569.64
39206	Хуримтлагдсан элэгдэл	-156,450,654.89	-177,993,151.82
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	47,473,420.00	49,173,420.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-19,309,906.65	-23,609,636.45
39209	Зам, гүүрийн байгууламж	746,403.36	746,403.36
39210	Хуримтлагдсан элэгдэл	-62,200.32	-124,400.64
39214	Бусад үндсэн хөрөнгө	120,233,500.00	129,883,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-52,439,468.63	-63,913,468.67
393	Биет бус хөрөнгө	68,616,000.00	68,616,000.00
39301	Програм хангамж	1,000,000.00	250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,000,000.00	-250,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	68,616,000.00	68,616,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,228,118,215.96</u>	<u>1,182,982,612.00</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,228,118,215.96</u>	<u>1,182,982,612.00</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,228,118,215.96	1,182,982,612.00
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	648,743,631.82	648,743,631.82
51101	Өмч: - төрийн	648,743,631.82	648,743,631.82
512	Хуримтлагдсан үр дүн	147,712,954.95	102,577,350.99
51210	Өмнөх үеийн үр дүн	147,712,954.95	147,712,954.95
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-45,135,603.96
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	431,661,629.19	431,661,629.19
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,228,118,215.96</u>	<u>1,182,982,612.00</u>

Баацагаан сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	575,944,900.00	411,201,075.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	256,619,800.00	39,180,244.00
120	Нийтлэг татварын бус орлого	256,619,800.00	39,180,244.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	256,619,800.00	39,180,244.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600,000.00	175,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	256,019,800.00	39,005,244.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	319,325,100.00	372,020,831.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	60,000.00	3,065,331.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	2,610,331.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	60,000.00	455,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	319,265,100.00	368,955,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	319,265,100.00	368,955,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	412,337,559.20	456,336,678.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	412,337,559.20	456,336,678.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	396,823,264.20	448,848,964.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	208,947,034.00	233,986,702.00
210101	Үндсэн цалин	208,947,034.00	233,986,702.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,376,873.00	29,289,817.00
210201	Тэтгэврийн даатгал	17,989,644.00	19,965,534.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,097,605.00	2,334,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,678,083.00	1,867,840.00
210204	Ажилгүйдлийн даатгал	416,331.00	463,749.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,195,210.00	4,657,894.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,592,738.00	17,445,974.48
210301	Гэрэл, цахилгаан	3,648,738.00	3,501,974.48
210302	Түлш, халаалт	13,944,000.00	13,944,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	38,975,780.00	33,106,905.00
210401	Бичиг хэрэг	3,409,550.00	5,420,070.00
210402	Тээвэр, шатахуун	19,201,900.00	19,444,930.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	689,400.00	132,600.00
210404	Ном, хэвлэл	00.00	2,001,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	299,130.00	99,350.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	721,500.00	3,048,755.00
210408	Бараа материал акталсны зардал	14,654,300.00	2,960,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,187,086.50	7,646,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	768,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	50,000.00
210604	Урсгал засвар	2,187,086.50	6,828,100.00

005 ТӨСВИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧМӨГҮЙ
САНАЛ ДААХ

Баацагаан сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2107	Томилолт, зочны зардал	9,616,800.00	4,238,000.00
210701	Гадаад албан томилолт	1,000,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	4,548,000.00	4,238,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	4,068,800.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,809,730.00	8,563,718.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,228,020.00	4,630,818.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	299,500.00	300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	395,410.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	202,800.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	120,000.00	70,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564,000.00	3,562,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	85,317,222.70	114,571,047.96
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,999,800.00	13,666,545.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	100,000.00	690,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	81,217,422.70	100,214,502.96
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,514,295.00	7,487,714.52
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,166,900.00	6,827,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	5,427,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,166,900.00	1,400,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,347,395.00	660,414.52
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,347,395.00	25,414.52
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	163,607,340.80	-45,135,603.96
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	5,639,649.69	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	5,639,649.69	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-5,639,649.69	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	157,967,691.11	-45,135,603.96

2.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	319,925,100.00	372,195,831.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	600,000.00	175,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	600,000.00	175,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	600,000.00	175,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600,000.00	175,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	319,325,100.00	372,020,831.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	60,000.00	3,065,331.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	2,610,331.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	60,000.00	455,000.00

Баацагаан сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	319,265,100.00	368,955,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	319,265,100.00	368,955,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	316,125,100.00	362,916,281.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	316,125,100.00	362,916,281.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	300,610,805.00	355,428,566.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	208,947,034.00	233,986,702.00
210101	Үндсэн цалин	182,759,834.00	196,994,050.00
210102	Нэмэгдэл	26,187,200.00	36,992,652.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,376,873.00	29,289,817.00
210201	Тэтгэврийн даатгал	17,917,457.00	19,953,007.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,104,396.00	2,347,381.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,683,195.00	1,867,854.00
210204	Ажилгүйдлийн даатгал	419,072.00	463,648.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,252,753.00	4,657,927.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,592,738.00	17,445,974.48
210301	Гэрэл, цахилгаан	3,648,738.00	3,501,974.48
210302	Түлш, халаалт	13,944,000.00	13,944,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,762,330.00	28,373,210.00
210401	Бичиг хэрэг	2,944,400.00	4,773,500.00
210402	Тээвэр, шатахуун	19,229,900.00	19,444,930.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	689,400.00	132,600.00
210404	Ном, хэвлэл	00.00	2,701,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	299,130.00	99,350.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	599,500.00	1,221,830.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,503,500.00	9,578,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	1,019,750.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	350,000.00
210604	Урсгал засвар	2,503,500.00	8,208,650.00
2107	Томилолт, зочны зардал	9,518,800.00	4,238,000.00
210701	Гадаад албан томилолт	1,000,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	4,520,000.00	4,238,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	3,998,800.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,809,730.00	8,563,718.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,228,020.00	4,630,818.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	299,500.00	300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	395,410.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	202,800.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	120,000.00	70,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564,000.00	3,562,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,099,800.00	23,952,745.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,999,800.00	23,262,745.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	100,000.00	690,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,514,295.00	7,487,714.52
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,166,900.00	6,827,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,566,900.00	5,427,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,600,000.00	1,400,000.00

005
ТӨСВИЙН АЖИЛТЭЙН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Баацагаан сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,347,395.00	25,414.52
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг		
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	635,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	3,800,000.00	9,279,550.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,800,000.00	9,279,550.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,800,000.00	9,279,550.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,800,000.00	9,279,550.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,800,000.00	9,279,550.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-3,800,000.00	-9,279,550.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	580,127,631.82	214,351,930.00	-89,202,105.73	705,277,456.09
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	580,127,631.82	214,351,930.00	-89,202,105.73	705,277,456.09
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-13,407,223.72	-13,407,223.72
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	648,743,631.82	431,661,629.19	147,712,954.95	1,228,118,215.96
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	648,743,631.82	431,661,629.19	147,712,954.95	1,228,118,215.96
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	648,743,631.82	431,661,629.19	147,712,954.95	1,228,118,215.96
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-45,135,603.96	-45,135,603.96
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	648,743,631.82	431,661,629.19	102,577,350.99	1,182,982,612.00



2.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Үзүүлэлт	Тайлант оны			хувь
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	388,300,900.00	369,105,085.48	19,195,814.52	95.06
УРСГАЛ ЗАРДАЛ	388,300,900.00	369,105,085.48	19,195,814.52	95.06
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	381,173,600.00	362,277,785.48	18,895,814.52	95.04
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	234,751,400.00	233,986,702.00	-764,698.00	99.67
Үндсэн цалин	198,845,400.00	196,994,050.00	-1,851,350.00	99.07
Нэмэгдэл	35,906,000.00	36,992,652.00	1,086,652.00	103.03
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,197,900.00	29,289,817.00	-3,908,083.00	88.23
Тэтгэврийн даатгал	23,360,400.00	19,953,007.00	-3,407,393.00	85.41
Тэтгэмжийн даатгал	2,459,300.00	2,347,381.00	-111,919.00	95.45
ҮОМШӨ-ний даатгал	1,967,500.00	1,867,854.00	-99,646.00	94.94
Ажилгүйдлийн даатгал	491,900.00	463,648.00	-28,252.00	94.26
Эрүүл мэндийн даатгал	4,918,800.00	4,657,927.00	-260,873.00	94.70
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,793,000.00	17,445,974.48	-347,025.52	98.05
Гэрэл, цахилгаан	3,649,000.00	3,501,974.48	-147,025.52	95.97
Түлш, халаалт	14,044,000.00	13,944,000.00	-100,000.00	99.29
Цэвэр, бохир ус	100,000.00	00.00	-100,000.00	00.00
Хангамж, бараа материалын зардал	31,172,600.00	28,373,210.00	-2,799,390.00	91.02
Бичиг хэрэг	5,106,800.00	4,773,500.00	-333,300.00	93.47
Тээвэр, шатахуун	21,686,800.00	19,444,930.00	-2,241,870.00	89.66
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	134,500.00	132,600.00	-1,900.00	98.59
Ном, хэвлэл	2,756,600.00	2,701,000.00	-55,600.00	97.98
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	260,000.00	99,350.00	-160,650.00	38.21
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,227,900.00	1,221,830.00	-6,070.00	99.51
Эд хогшил, урсгал засварын зардал	24,116,000.00	18,857,950.00	-5,258,050.00	78.20
Багаж, техник, хэрэгсэл	10,500,000.00	7,598,150.00	-2,901,850.00	72.36
Тавилга	3,000,000.00	1,909,800.00	-1,090,200.00	63.66
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	992,000.00	350,000.00	-642,000.00	35.28
Урсгал засвар	9,624,000.00	9,000,000.00	-624,000.00	93.52
Томилолт, зочны зардал	6,927,800.00	4,238,000.00	-2,689,800.00	61.17
Дотоод албан томилолт	6,927,800.00	4,238,000.00	-2,689,800.00	61.17
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,987,900.00	6,133,387.00	-1,854,513.00	76.78
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,023,300.00	2,200,487.00	-1,822,813.00	54.69
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	300,000.00	00.00	100.00
Тээврийн хэрэгслийн татвар	31,500.00	00.00	-31,500.00	00.00

Баацагаан сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тээврийн хэрэгслийн оношлогоо	70,000.00	70,000.00	00.00	100.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,563,100.00	3,562,900.00	-200.00	99.99
Бараа үйлчилгээний бусад зардал	25227000.00	23952745.00	-1,274,255.00	94.95
Бараа үйлчилгээний бусад зардал	24,227,000.00	23,262,745.00	-964,255.00	96.02
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	690,000.00	-310,000.00	69.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7127300.00	6827300.00	-300,000.00	95.79
Бусад урсгал шилжүүлэг	7,127,300.00	6,827,300.00	-300,000.00	95.79
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	5,427,300.00	5,427,300.00	00.00	100.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,700,000.00	1,400,000.00	-300,000.00	82.35
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	388,300,900.00	369,105,085.48	19,195,814.52	95.06
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	387,300,900.00	368,930,085.48	18,370,814.52	95.26
Орон нутгийн төсвөөс	387,300,900.00	368,930,085.48	18,370,814.52	95.26
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,000,000.00	175,000.00	-825,000.00	17.50
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	175,000.00	-825,000.00	17.50
АЖИЛЛАГСАДЫН ТОО	24	21	-03	87.50
Удирдах ажилтан	10	10	00	100.00
Гүйцэтгэх ажилтан	11	08	-03	72.73
Үйлчлэх ажилтан	03	03	00	100.00
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	24	21	-03	87.50
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	08	05	-03	62.50
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	07	07	00	100.00
Улс төрийн албан хаагч (УТ)	09	09	00	100.00

2.6 Аудит хийгдсэн нэмэлт дансны гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	60000.00	3,065,331.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	60000.00	3,065,331.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	60000.00	3,065,331.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	60000.00	2,430,331.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		635,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	60000.00	3065331.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	60000.00	3,065,331.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		2,610,331.00

Баацагаан сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	60000.00	455,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Баацагаан сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг ЗДТГ-ын дарга Б.Наранбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав

Аудитыг 2021.02.21-ээс 2021.02.23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021.02.23-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Цэрэнчимэд хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Баацагаан сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх хүсэлтээ Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020.11.09-ны өдрийн 1/111 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Баянхонгор аймгийн Баацагаан сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны чиглэлийг “Монгол улсын Засгийн газар, аймгийн ИТХ, Засаг даргаас тавьж буй хөтөлбөр зорилтыг хэрэгжүүлэх, сум, орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжлийн тогтвортой байдлыг хангах, хууль ёсыг чандлан сахиулж, төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй шуурхай хүргэхэд оршино” гэж тодорхойлжээ.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баянхонгор аймгийн Баацагаан сумын ЗДТГ-ын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нийт зардлын 326544.8 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 6530.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 456336.6 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 9126.7 мянган төгрөгөөр материаллаг байдлын суурийн дахин тооцсон.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баацагаан сумын ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 13285,6 мянган төгрөгөөр буюу 13.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	19,281.0	27,322.7	8,041.7
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	19,281.0	27,322.7	8,041.7
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,208,837.2	1,155,659.9	(53,177.3)
Үндсэн хөрөнгө	1,757,748.1	1,804,035.2	46,287.2
Хуримтлагдсан элэгдэл	(548,910.9)	(648,375.4)	(99,464.5)
Нийт хөрөнгө	1,228,118.2	1,182,982.6	(45,135.6)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,228,118.2	1,182,982.6	(45,135.6)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,228,118.2	1,182,982.6	(45,135.6)

Эх сурвалжийг/ Санхүүгийн тайлангаас авав/

Бараа материалын үлдэгдэл 27322.7 мянган төгрөг болж 8041.7 мянган төгрөгөөр өссөн нь бусад хангамжийн зардалд нөөцийн өвс 9496,2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, бичиг хэрэг 53,4 мянган төгрөгөөр өссөн, , аж ахуй 1082,1 мянга, мал амьтны үлдэгдэл 425.0 мянган төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 1155659.9 мянган төгрөг болж 46287.2 мянган төгрөгөөр өссөн нь Барилга байгууламж 24406,4 мянга, тоног төхөөрөмж 11282,7 мянга, тавилга 1700,0 мянга, бусад үндсэн хөрөнгө 9650.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, программ хангамж 750,0 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1182982,6 мянган төгрөг болж 45135,6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгийн 45135.6 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.



Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 411201,1 мянган төгрөг болж өмнөх оноос 164743,8 мянган төгрөгөөр буюу 28.6 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 217439,5 мянган төгрөгийн орлого байна. Энэ нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 217014.5 мянга, үндсэн үйл ажиллагааны орлого 425,0 мянган төгрөгөөр тус тус буурч, нэмэлт санхүүжилтийн орлого 3005.3 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Нийт үйл ажиллагааны зардал 456336,6 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 43999.1 мянган төгрөгөөр буюу 10.67 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд байна. Энэ нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ-ын зардал 27952.6 мянга, эд хогшил, урсгал засварын зардал 5459.7 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 754.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 29253.8 мянган төгрөгөөр тус тус өссөн, байр ашиглалтын тогтмол зардал 146.7 мянга, хангамжийн зардал 5868.8 мянга, албан томилолтын зардал 5378.8 мянга, бусад урсгал зардал 8026.6 мянган төгрөгөөр тус тус буурсантай холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 394443.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 394443.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 394443.2 мянган төгрөг батлагдсанаас 1 удаагийн зохицуулалт хийж 6142.3 мянган төгрөгөөр хасаж 388300.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 388300,5 мянган төгрөгийн батлагдсан төсвөөс орон нутгийн орлого тасарсан тул санхүүжилтийг 18370.8 мянган төгрөгөөр дутуу, үйл ажиллагааны орлого 825.0 мянган төгрөгөөр дутуу орсонтой холбоотой байна. Тайлант хугацаанд үйл ажиллагааны зардалд 369105.1 мянган төгрөгийг зарцуулж, 25,4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 369105.1 мянган төгрөг буюу 95.0 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардал 7567.2 мянга, баг хорооны үйл ажиллагааны зардал 8119.2 мянга, ажил олгогчоос олгох тэтгэмж 70000.0 мянга, орон нутгийн нөөц хөрөнгө 1473.2 мянга, хур хог хаягдлын зардлыг 1966.2 мянган төгрөгөөр тус тус дутуу санхүүжүүлсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Баацагаан сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
ХӨТӨЛБӨР 70106	388,300,900.00	369,105,085.48	19,195,814.52	95.06
АРГА ХЭМЖЭЭ 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	266,419,300.00	258,852,095.48	7,567,204.52	97.16
АРГА ХЭМЖЭЭ 80106 Баг, хорооны үйл ажиллагааны зардал	88,794,200.00	80,674,945.00	8,119,255.00	90.86
АРГА ХЭМЖЭЭ 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	6,427,300.00	6,357,300.00	70,000.00	98.91
АРГА ХЭМЖЭЭ 81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	23,500,000.00	22,026,745.00	1,473,255.00	93.73
АРГА ХЭМЖЭЭ 82212 Хур хог хаягдал орчны бохирдол	3,160,100.00	1,194,000.00	1,966,100.00	37.78
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	388,300,900.00	369,105,085.48	19,195,814.52	95.06
Орон нутгийн төсвөөс	387,300,900.00	368,930,085.48	18,370,814.52	95.26
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	175,000.00	825,000.00	17.50

/Тухайн байгууллага олон хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилттэй бол хавсралтаар оруулах, цөөн тохиолдолд тайлангийн хэсэгт хүснэгтээр үзүүлэх/

Баацагаан сумын ЗДТГ нь 1 хөтөлбөр, 5 арга хэмжээгээр төсвийг баталж зарцуулж байгаа бөгөөд зардлын хэтрэлт хэмнэлтийг дэлгэрэнгүй байдлаар харуулсан хүснэгийг ажлын баримтад хавсаргасан болно.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн Статистикийн хэлтсээс судалгаа, мал тооллогын зардалд 1610.3 мянган, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас сургалт, сурталчилгааны зардалд 1000,0 мянган цахим тендерийн орлого 455,0 мянга нийт 3065,3 мянган төгрөгийн орлого орж, 2430.3 мянган төгрөг зарцуулж, 635.0 мянган төгрөг буцаан төвлөрүүлсэн байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллийн сайтад нийт 27 төрлийн 151 мэдээлэл байршуулахаас 141 мэдээллийг хугацаанд нь 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 6 мэдээлэл байршуулах хугацаа болоогүй байна.

Шилэн дансны сайтад 5,0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мэдээлэл болон зарлагын 5,0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий мэдээллийг бүрэн байршуулжээ.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд нь байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Байршуу лаагүй	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	4	2	0	5
2	Хагас жил	4	4	4	0	0	
3	Улирал бүр	1	4	3		0	1
4	Сар бүр	5	36	36	0	0	
5	Тухай бүр	8	96	94	2	0	
6	Нийт	29	151	141	4	0	6

Эх сурвалжийг/ байгууллагын шилэн данснаас авав/

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өнгөрсөн оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй, шилэн дансанд 1132.0 мянган төгрөгийн мэдээлэл байршуулах 1 албан шаардлага, 4 зөвлөмж өгсөн бөгөөд хэрэгжилтийг 2020.03.26-ны 2/40 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аймгийн ИТХТ-ийн 2008.06.16-ны 102-р тогтоолоор тус сумын 2 цахилгаан моторыг аймгийн "Баянхонгор-Эрчим хүч" ХХК-д шилжүүлэх шийдвэр гарсан боловч тухайн үед аймгийн ОНӨГ-ын өгсөн чиглэлийн дагуу данснаас хасаагүй хөрөнгийн үлдэгдлээр бүртгэлтэй явж иржээ. Тус байгууллагын хөрөнгөд 3 ширхэг ПСЕ-125 мотор 29429,9 мянган төгрөгийн үнэтэй бүртгэлтэй боловч биетээр 19619.7 мянган төгрөгийн 2ш мотор /"Баянхонгор-Эрчим хүч" ХХК-ний/ байхгүй, нөөцөд бүртгэлтэй байгаа 9810.2 мянган төгрөгийн нэг мотор нь эвдэрч ашиглах боломжгүй болсон гэсэн тайлбарыг нягтлан бодогч өгсөн.

Мөн тайлант онд Сумын Ой ангиас 37148,0 мянган төгрөгийн өвс тэжээлийг нийлүүлсэн байхад орлого, зарлагын бүртгэлд бүртгээгүй, өвсний үнээс 5580,0 мянган төгрөг төлөгдсөн, 31568,0 мянган төгрөг төлөгдөөгүй байхад авлага, өглөгийн тооцоо хийгээгүй зөрчил илэрч, зөрчлийг арилгах албан шаардлагыг тус тус хүргүүлээ

Залруулсан алдаа

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгээгүй болно.

Аудитын зөвлөмж

Аудитаар шилэн дансны мэдээлэлд 2 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан тул 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Аймгийн ИТХТ-ийн 2008.06.16-ны 102-р тогтоолоор тус сумын 2 цахилгаан моторыг аймгийн "Баянхонгор-Эрчим хүч" ХХК-д шилжүүлэх шийдвэр гарсан боловч данснаас хасаагүй, нөөцөд бүртгэлтэй байгаа 9810.2 мянган төгрөгийн нэг мотор нь эвдэрч ашиглах боломжгүй болсон

1.2 Эрсдэл: Хөрөнгийн ашиглалтын байдлыг хангахгүй байх

1.3 Өгсөн зөвлөмж: Төрийн өмчин бодлого зохицуулалтын газрын 2019.06.18-ны өдрийн 271-р тогтоолоор батлагдсан журмын 6.1 дэх заалтыг хэрэгжүүлж, ашиглалтгүй үндсэн хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах.

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөрчлийг давтан гаргахгүй, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. Хөрөнгийн данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Шилэн дансны мэдээллийн сайтад нийт 27 төрлийн 151 мэдээлэл байршуулахаас 141 мэдээллийг хугацаанд нь 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4-р зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх", 6-р зүйлийн 6.1 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" заалтыг тус тус зөрчсөн байна.

2.2 Эрсдэл: Хөрөнгийн зарцуулалтын ил, тод байдлыг хангахгүй байх

2.3 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны хуулийн дагуу шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулж байх.

2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөрчлийг давтан гаргахгүй, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР



Б.ЦЭРЭНЧИМЭД 2021.02.23

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД

АУДИТЫН МЕНЕЖЕР

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЦЭЭНЯМ 2021.02.23

Б.МӨНХБАТ 2021.02.23

Баацагаан сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020.12.31	Аудитын нэр:	2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: БНА-2021/5/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Баянхонгор аймгийн Баянхонгор аймгийн Баацагаан сумын ЗДТГ-ын		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5
1	Аймгийн ИТХТ-ийн 2008.06.16-ны 102-р тогтоолоор тус сумын 2 цахилгаан моторыг аймгийн "Баянхонгор-Эрчим хүч" ХХК-д шилжүүлэх шийдвэр гарсан боловч данснаас хасаагүй, нөөцөд бүртгэлтэй байгаа 9810.2 мянган төгрөгийн нэг мотор нь эвдэрч ашиглах боломжгүй болсон байна.	24429.8	зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Б.Наранбаатар, Д.Анхтуяа
2	Ой ангиас нийлүүлсэн 37148,0 мянган төгрөгийн өвс тэжээл, 31568,0 мянган төгрөгийн өглөгийг данс бүртгэлд тусгаагүй, авлага өглөгийн тооцоо хийгээгүй байна.	31568.0	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Б.Наранбаатар, Д.Анхтуяа
3	Шилэн дансны мэдээллийн сайтад нийт 27 төрлийн 151 мэдээлэл байршуулахаас 141 мэдээллийг хугацаанд нь 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	0	зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Б.Наранбаатар, Д.Анхтуяа
ДҮН		55997.8			